



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/123/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Б.Ундаръяа

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БШУ	Боловсрол шинжлэх ухаан

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.5 Аудит хийсэн Нэмэлт санхүүжилтийнн тайлан	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СТА-2022/123-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,955,870.72	44,048,225.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	50,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	50,000.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	33,955,870.72	43,998,225.72
35100	Түүхий эд материал	0.00	9,554,855.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	9,409,400.00
35130	Эм боох материал	0.00	145,455.00
35400	Хангамжийн материал	33,955,870.72	34,443,370.72
35410	Бичиг хэргийн материал	5,701,930.72	5,701,930.72
35420	Аж ахуйн материал	28,253,940.00	28,741,440.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,195,308,290.43	1,173,575,488.08
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,195,308,290.43	1,173,575,488.08
39200	Биет хөрөнгө	1,189,038,623.79	1,167,618,321.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,123,133,900.00	1,123,133,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(56,631,352.04)	(83,722,027.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,499.68)	(14,562,499.68)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	106,243,113.10	115,093,022.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,617,968.51)	(47,042,741.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,795,517.64	80,985,037.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(41,293,680.74)	(35,760,447.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,865,400.00	7,865,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(383,678.16)	(575,517.24)
39217	Ном	6,927,372.18	7,641,695.86
39300	Биет бус хөрөнгө	6,269,666.64	5,957,166.60
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(208,333.36)	(520,833.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,228,000.00	5,228,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,229,264,161.15	1,217,623,713.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,229,264,161.15	1,217,623,713.80
51	Засгийн газрын хувь оролцоо	1,229,264,161.15	1,217,623,713.80
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	462,309,496.49	462,309,496.49
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	457,081,496.49	457,081,496.49
51200	Хуримтлагдсан үр дүн	66,857,520.36	55,217,073.01
51210	Өмнөх үеийн үр дүн	66,857,520.36	66,857,520.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	(11,640,447.35)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	700,097,144.30	700,097,144.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,229,264,161.15	1,217,623,713.80

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	858,098,946.42	810,407,003.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,453,275.42	23,931,100.32
120	Нийтлэг татварын бус орлого	17,453,275.42	23,931,100.32
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,453,275.42	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,453,275.42	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		11,201,223.68
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		12,729,876.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	840,645,671.00	786,475,903.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	744,505,600.00	638,091,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	690,882,200.00	638,091,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	53,623,400.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000.00	4,725,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,105,071.00	143,659,903.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,105,071.00	143,659,903.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	830,783,588.85	822,097,450.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	830,783,588.85	822,097,450.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	746,600,378.85	794,126,512.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,911,771.00	497,354,433.00
210101	Үндсэн цалин	436,329,524.00	331,987,452.00
210102	Нэмэгдэл	19,626,829.00	134,153,188.00
210104	Урамшуулал	36,955,418.00	31,213,703.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,964,209.00	63,549,929.00
210201	Тэтгэврийн даатгал	42,392,447.00	44,746,760.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,962,068.00	4,927,667.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,952,855.00	3,900,828.00
210204	Ажилгүйдлийн даатгал	965,345.00	915,269.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,691,494.00	9,059,405.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,921,524.00	143,214,303.00
210301	Гэрэл, цахилгаан	6,165,211.00	7,015,003.00
210302	Түлш, халаалт	87,156,313.00	134,591,300.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	1,608,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,678,094.24	8,411,083.76
210401	Бичиг хэрэг	231,400.00	731,150.00
210402	Тээвэр, шатахуун	798,840.00	1,741,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	177,200.00	1,080,000.00
210404	Ном, хэвлэл	693,648.45	366,964.76
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,092,700.00	1,311,100.00

**Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,288,575.79	3,180,069.00
210408	Бараа материал акталсны зардал	12,395,730.00	0.00
2105	Нормативт зардал	13,614,740.00	23,114,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	154,000.00	1,348,900.00
210502	Хоол, хүнс	12,770,740.00	20,783,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	690,000.00	982,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,697,800.00	5,026,200.00
210604	Урсгал засвар	5,697,800.00	5,026,200.00
2107	Томилолт, зочны зардал	126,000.00	126,000.00
210702	Дотоод албан томилолт	126,000.00	126,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	913,500.00	4,101,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	481,500.00	3,453,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,772,740.61	49,228,863.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,542,355.95	1,899,137.88
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,430,384.66	47,329,726.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,183,210.00	27,920,938.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,373,480.00	14,299,450.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,773,480.00	13,899,450.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,809,730.00	13,621,488.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,809,730.00	13,621,488.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(27,315,357.57)	(11,640,447.35)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(27,315,357.57)	(11,640,447.35)

2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	840,645,671.00	786,475,903.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	840,645,671.00	786,475,903.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	744,505,600.00	638,091,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	690,882,200.00	638,091,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	53,623,400.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000.00	4,725,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,725,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,105,071.00	143,659,903.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,105,071.00	143,659,903.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	772,676,471.00	772,080,203.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	772,676,471.00	772,080,203.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	688,814,411.00	744,159,265.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,911,771.00	496,157,007.00
210101	Үндсэн цалин	436,329,524.00	332,037,542.00
210102	Нэмэгдэл	19,626,829.00	134,153,188.00
210104	Урамшуулал	36,955,418.00	29,966,277.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,964,209.00	64,797,355.00
210201	Тэтгэврийн даатгал	42,392,447.00	45,994,186.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,962,068.00	4,927,667.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,952,855.00	3,900,828.00
210204	Ажилгүйдлийн даатгал	965,345.00	915,269.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,691,494.00	9,059,405.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,605,071.00	143,214,303.00
210301	Гэрэл, цахилгаан	7,848,758.00	7,015,003.00
210302	Түлш, халаалт	87,156,313.00	134,591,300.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	1,608,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,925,340.00	7,295,600.00
210401	Бичиг хэрэг	231,400.00	621,800.00
210402	Тээвэр, шатахуун	798,840.00	1,741,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	177,200.00	1,080,000.00
210404	Ном, хэвлэл	157,800.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,092,700.00	1,033,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,467,400.00	2,818,600.00
2105	Нормативт зардал	12,475,370.00	23,114,700.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	154,000.00	1,348,900.00
210502	Хоол, хүнс	11,631,370.00	20,783,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	690,000.00	982,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,647,800.00	3,986,200.00
210602	Тавилга	4,500,000.00	0.00
210604	Урсгал засвар	6,147,800.00	3,986,200.00
2107	Томилолт, зочны зардал	126,000.00	126,000.00
210702	Дотоод албан томилолт	126,000.00	126,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,163,500.00	4,101,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	481,500.00	3,453,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,995,350.00	1,367,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,195,350.00	1,367,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,862,060.00	27,920,938.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,052,330.00	14,299,450.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,452,330.00	13,899,450.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,809,730.00	13,621,488.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,809,730.00	13,621,488.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	67,969,200.00	14,395,700.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	20,095,800.00	14,395,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,095,800.00	14,395,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,095,800.00	14,395,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,095,800.00	14,395,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(20,095,800.00)	(14,395,700.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	47,873,400.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	462,309,496.49	700,097,144.30	66,857,520.36	1,229,264,161.15
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	462,309,496.49	700,097,144.30	66,857,520.36	1,229,264,161.15
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(11,640,447.35)	(11,640,447.35)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	462,309,496.49	700,097,144.30	55,217,073.01	1,217,623,713.80

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	781,780,300.00	781,750,903.00	29,397.00	100.00%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	781,780,300.00	768,751,203.00	13,029,097.00	98.33%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	761,659,600.00	740,830,265.00	20,829,335.00	97.27%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	497,231,800.00	496,157,007.00	1,074,793.00	99.78%
210101	Үндсэн цалин	364,214,200.00	332,037,542.00	32,176,658.00	91.17%
210102	Нэмэгдэл	103,277,500.00	134,153,188.00	(30,875,688.00)	129.90%
210104	Урамшуулал	29,740,100.00	29,966,277.00	(226,177.00)	100.76%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,478,600.00	64,797,355.00	1,681,245.00	97.47%
210201	Тэтгэврийн даатгал	46,589,300.00	45,994,186.00	595,114.00	98.72%
210202	Тэтгэмжийн даатгал	4,972,300.00	4,927,667.00	44,633.00	99.10%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,977,900.00	3,900,828.00	77,072.00	98.06%
210204	Ажилгүйдлийн даатгал	994,500.00	915,269.00	79,231.00	92.03%
210205	Эрүүл мэндийн даатгал	9,944,600.00	9,059,405.00	885,195.00	91.10%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,243,700.00	143,214,303.00	29,397.00	99.98%
210301	Гэрэл, цахилгаан	7,927,100.00	7,015,003.00	912,097.00	88.49%
210302	Түлш, халаалт	134,591,300.00	134,591,300.00	-	100.00%
210303	Цэвэр, бохир ус	725,300.00	1,608,000.00	(882,700.00)	221.70%
2104	Хангамж, бараа материалын зардал	6,869,600.00	6,869,600.00	-	100.00%
210401	Бичиг хэрэг	215,700.00	604,800.00	(389,100.00)	280.39%
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	1,741,800.00	(941,800.00)	217.73%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,002,600.00	955,000.00	47,600.00	95.25%
210404	Ном, хэвлэл	395,400.00	0.00	395,400.00	0.00%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,206,000.00	749,400.00	1,456,600.00	33.97%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,249,900.00	2,818,600.00	(568,700.00)	125.28%
2105	Нормативт зардал	28,138,300.00	23,114,700.00	5,023,600.00	82.15%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,348,900.00	1,348,900.00	-	100.00%
210502	Хоол, хүнс	25,803,700.00	20,783,700.00	5,020,000.00	80.55%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	985,700.00	982,100.00	3,600.00	99.63%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,986,200.00	3,986,200.00	13,000,000.00	23.47%

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00	-	8,000,000.00	0.00%
210602	Тавилга	5,000,000.00	-	5,000,000.00	0.00%
210604	Урсгал засвар	3,986,200.00	3,986,200.00	-	100.00%
2107	Томилолт, зочны зардал	145,800.00	126,000.00	19,800.00	86.42%
210702	Дотоод албан томилолт	145,800.00	126,000.00	19,800.00	86.42%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,198,500.00	1,198,000.00	500.00	99.96%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	550,500.00	550,000.00	500.00	99.91%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00	-	100.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,367,100.00	1,367,100.00	-	100.00%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,367,100.00	1,367,100.00	-	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,120,700.00	27,920,938.00	(7,800,238.00)	138.77%
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,120,700.00	14,299,450.00	5,821,250.00	71.07%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,720,700.00	13,899,450.00	5,821,250.00	70.48%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00	-	100.00%
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		13,621,488.00	(13,621,488.00)	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		13,621,488.00	(13,621,488.00)	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	12,999,700.00	(12,999,700.00)	
220001	Дотоод эх үүсвэрээс	0.00	12,999,700.00	(12,999,700.00)	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	781,780,300.00	781,750,903.00	29,397.00	100.00%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	638,091,000.00	638,091,000.00	-	100.00%
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	638,091,000.00	638,091,000.00	-	100.00%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	143,689,300.00	143,659,903.00	29,397.00	99.98%
320001	Орон нутгийн төсвөөс	143,689,300.00	143,659,903.00	29,397.00	99.98%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		100.00%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		100.00%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44.00	44.00		100.00%
620001	Удирдах ажилтан	4.00	4.00		100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	26.00	26.00		100.00%
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00		100.00%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	300.00	278.00	22.00	92.67%
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	300.00	278.00	22.00	92.67%
630001	Төрийн өмчит ЕБС	300.00	278.00	22.00	92.67%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44.00	44.00	-	100.00%

2.5 Аудит хийсэн НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,725,000.00	(4,725,000.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,329,000.00	(3,329,000.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,329,000.00	(3,329,000.00)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		-	-
210101	Үндсэн цалин		-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		-	-
2104	Хангамж, бараа материалын зардал		426,000.00	(426,000.00)
210401	Бичиг хэрэг		17,000.00	(17,000.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		125,000.00	(125,000.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		284,000.00	(284,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,903,000.00	(2,903,000.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,903,000.00	(2,903,000.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал			-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ			-
2132	Бусад урсгал шилжүүлэг			-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,396,000.00	(1,396,000.00)
2200	Дотоод эх үүсвэрээр		1,396,000.00	(1,396,000.00)
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,725,000.00	(4,725,000.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,725,000.00	(4,725,000.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,725,000.00	(4,725,000.00)
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын ерөнхий боловсролын сургуулийн */цаашид Жавхлант сумын ерөнхий боловсролын сургууль гэх/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримт, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Б.Ундаръяа, аудиторын туслах Б.Сувд-Эрдэнэ нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жавхлант сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар-т 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жавхлант сумын ерөнхий боловсролын сургууль нь *“Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих бие даан суралцахад нь ахиц гаргана”* гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жавхлант сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 830,783.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,307.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,815.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Жавхлант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,640.4 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		50.0	50.0
Бараа материал	33,955.8	43,998.2	10,042.4
Үндсэн хөрөнгө	1,195,308.3	1,173,575.5	(21,732.8)
Нийт хөрөнгө	1,229,264.1	1,217,623.7	(11,640.4)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,229,264.1	1,217,623.7	(11,640.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,229,264.1	1,217,623.7	(11,640.4)

Авлага дансны үлдэгдэл 50.0 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн авлага суутгаагүйгээс шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 10,042.4 мянган төгрөгөөр өссөн нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 9,409.4 мянган төгрөгийн, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 2,784.5 мянган төгрөгийн, аймгийн БСШУЯ-с 367.0 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, гар ариутгагч, Жайка ОУБ-с 169.0 мянган төгрөгийн ариутгалын материал буюу нийт 12,729.9 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 49,140.3 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 51,827.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 753.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БШУЯ-наас 5,861.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном, Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас 5,340.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 14,395.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, сумын ИТХТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 39 дугаар тогтоолоор үлдэх өртөггүй 24,843.2 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,217,623.7 мянган төгрөг болж 11,640.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

Жавхлант сумын ерөнхий боловсролын сургуулийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 47,692.0 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих санхүүжилт буурсан нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 8,736.1 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан нь хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал буурсан нь голлон шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 744,142.8 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд нэг хүүхдэд ногдох хоолны зардал нэмэгдсэнтэй холбоотойгоор төсөвт өөрчлөлт орсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр **781,780.3** мянган төгрөгийн төсөв баталснаас 638,091.0 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 143,689.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 638,091.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 143,659.9 мянган төгрөгийн санхүүжилт буюу нийт 781,750.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **768,129.4** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 13,621.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 768,129.4 мянган төгрөг буюу 98.2 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ийн зардал 2,756.0 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 5,020.0 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардал 5,821.3 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БШУЯ-с төслийн санхүүжилт 4,299.0 мянган төгрөгийн, БСГ-аас ариутгал халдваргүйжүүлэлт 284.0 мянган төгрөг, үнэлгээний шалгалтын зардалд 142.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг

журмын 3 дахь “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%” гэж заасан боловч сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын хоёрдугаар хавсралт “Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 146 мэдээллийг бүрэн оруулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Жавхлант сумын ерөнхий боловсролын сургуульд 781,780.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 768,129.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 1.8 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 34,497.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 92.2 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 1 албан шаардлага хүргүүлэн, 34,405.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд цалингийн авлага 50.0 мянган төгрөгийг тусгаагүй, бичиг хэргийн материалын тайлангийн эхний үлдэгдэл 42.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасныг залруулав.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 34,405.2 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар*

төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх

1.2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

1.2.1 Илрүүлэлт Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3, 6.4.5 дахь заалтуудыг зөрчсөн байгаа тул холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жавхлант сумын Ерөнхий боловсролын сургууль	4	34,497.4	1	92.2			1	-	2	34,405.2

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.